



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/207

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:  
1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Говь-Угтаал сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд суудлын авто машин" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Т.Уранбайгаль (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

Гишүүд:

Д.Сэргэлэнбаатар (Дундговь-Ус орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий инженер)

Б.Отгонсайхан ("Мандалын гэгээ хот Тохижуулах газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер)  
Э.Энхжаргал (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг:

Б.Сайхантуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Т.Уранбайгаль)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



48 100602